

ГАДААД БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ “БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН”-ГИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

/АНУ-ын жишээн дээр/

П.Мягмардорж-Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн ахлах багш

Удиртгал

Олон улсын харилцааны гол оролцогч болох үндэстний төрт улсууд олон улсын харилцаа, геополитик, гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийдэг бодлогын судалгааны хүрээлэнгүүдтэй (*think-tank*) хамтран ажиллаж, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжин ажиллахын зэрэгцээ судалгааны үр дүнг нь бодлого боловсруулалт болон шийдвэр гаргах үйл явцад өргөнөөр ашигладаг болжээ.

Мөн нөлөө бүхий судлаачдын судалгааны ажлууд ч тухайн улсын гадаад бодлогын шийдвэр гаргалтад ихээр нөлөөлсөн жишээ ч олон байдаг. Тухайлбал "Форен Полиси"^{1 2} сэтгүүлийн 2014 оны 9 сард хэвлэгдсэн “Олон улсын харилцааны хамгийн нөлөө бүхий судлаач хэн бэ?”³ хэмээх өгүүлэлд бичсэнээр хүйтэн дайнаас хойш АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтад хамгийн их нөлөө үзүүлсэн судлаачдын жагсаалтыг Жозеф Най (*Америкийн гадаад бодлого дахь зөөлөн хүчний үүрэг*) тэргүүлсэн бол Самуэль Хантингтон (*соёл иргэшиллийн мөргөлдөөн ба АНУ-ын стратеги*), Хенри Киссенжер (*олон туйлт ертөнц ба Америкийн гадаад бодлого*), Франсис Фукуяма (*түүхийн төгсгөл ба Америкийн либераль үнэт зүйлсийг төгсгөн дэлгэрүүлэх бодлого*), Збигнев Бжежинский (*шатрын аварга хөлөг ба АНУ-ын геостратегийн бодлого*) нар удаах байрыг эзэлжээ.

Эндээс харахад нэр хүнд бүхий судлаачдын судалгааны ажлын үр дүнг ашиглах тал дээр АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргачид онцгой анхаардаг нь харагдаж байна. Үүний зэрэгцээ олон улсын харилцааны салбар ухаан анх улс төрийн шинжлэх ухаанаас салбарлан дэлхийн 1-р дайны дараа Их Британид төвтэй үүссэн⁴ бол дэлхийн 2-р дайн эхэлсэнээр олон улсын харилцаа, тэр дундаа гадаад бодлого, гадаад бодлогын шийдвэр гаргалтын онолын суурь судалгаа АНУ-д хүчтэй хийгдэх болсоноор энэ талын судалгаанд АНУ-ын их сургууль, судалгааны хүрээлэн, судлаачид тэргүүлэх байр суурь эзлэх болжээ.

Тинк танк буюу бодлогын судалгааны хүрээлэн гэдэг нь нийгэм эдийн засаг, цэрэг улс төр, олон улсын харилцаа ба гадаад бодлого, батлан хамгаалах болон

¹ Англи хэлний "Think tank" хэмээх ойлголт нь 1958 оноос англи хэлнээ хэрэглэгдэж эхэлсэн ба анхны ийнхүү нэрлэгдсэн судалгааны байгууллага нь Стэнфордын Их Сургуулийн дэргэдэх Бихевиорын Шинжлэх Ухааны Ахисан Түвшний Судалгааны Төв юм. 1960-аад оноос янз бүрийн судалгааны төв, хүрээлэн, корпораци зэрэг судалгааны байгууллагуудыг "Тинк танк" хэмээн нэрлэж хэвшсэн байна. Харин уг олголтыг энэхүү судалгааны ажилдаа "Бодлогын Судалгааны Хүрээлэн" хэмээн хөрвүүлэн хэрэглэв.

² Foreign Policy

³ Thomas Ricks. E. "Who are the top international-relations specialists? Surprise! Scholars have a very different view than policymakers do" Foreign Policy, September 25, 2014

⁴Эйберсвит дэх Уэльсийн Их Сургуульд анхны олон улсын харилцааны профессорын орон тоо бий болсон бол, анхны олон улсын харилцааны хүрээлэн болох "Чатхам Хаус" мөн Их Британид байгуулагдаж эдгээрийн хүрээнд олон улсын харилцаа, нэн ялангуяа дайн баянгийн асуудлыг шинжлэх ухааны үндэстэйгээр судладаг болсон.

аюулгүй байдлын стратеги, техник технологи, соёл иргэншлийн гэх мэт олон чиглэлээр бодлогын судалгаа хийдэг байгууллага юм.

Бодлогын судалгааны хүрээлэн нь төрийн бодлогын асуудлаар шийдвэр гаргагчдад туслах, олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор дотоодын болон олон улсын асуудлаар бодлогын баримжаа бүхий судалгаа шинжилгээг гүйцэтгэн зөвлөмж боловсруулдаг.¹ Үүний тулд тодорхой чиглэлийн бодлогын судалгаа, дүн шинжилгээний чиглэлээр мэргэшсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, бодит баримтад суурилсан бодлогын зөвлөмжийг чанарын өндөр түвшинд боловсруулах хүний нөөцтэй байх ёстой. Бодлогын судалгааны хүрээлэн нь төрийн болон төрийн бус статустай байх бөгөөд үндсэн санхүүжилт нь зөвлөгөө өгөх, судалгаа хийх, төсөл хэрэгжүүлэх зэргээс бүрддэг ба зарим улсууд төрөөс тодорхой хэмжээний санхүүжилт олгохын зэрэгцээ татварын хөнгөлөлт эдлүүлдэг байна.²

Гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийдэг дэлхийн анхны бодлогын судалгааны хүрээлэн нь 1831 онд Их Британид байгуулагдсан *"Батлан Хамгаалах болон Аюулгүй Байдал Судлалын Хааны Хамтарсан Хүрээлэн"*³ юм. Өнөөдрийн байдлаар дэлхий даяар янз бүрийн чиглэлээр бодлогын судалгаа хийдэг 7500 орчим хүрээлэн үйл ажиллагаа явуулж буйгаас 90 гаруй хувь нь 1951 оноос хойш. 50 орчим хувь нь 1980 оноос хойш байгуулагдсан ажээ.⁴ Эндээс харахад улс орнууд шинжлэх ухааны үндэслэл сайтай судалгаа шинжилгээнд тулгуурласан бодлогын шийвэр гаргахад анхаарах хандлага жил ирэх тусам нэмэгдэж байна.

АНУ-ын Пенсильваны Их Сургуулийн Лаудерийн Хүрээлэн 1989 оноос эхлэн *"Бодлогын Судалгааны Хүрээлэн ба Иргэний Нийгмийн Хөтөлбөр"* төслийн хүрээнд хийсэн судалгаандаа дэлхийн янз бүрийн орны 6500 орчим бодлогын судалгааны хүрээлэнг хамруулан нийт 13 удаагийн "дэлхийн тинк танкуудын индексийн тайлан"⁵-г бичиж хэвлүүлжээ. Тус их сургуулийн профессор, дээрх хөтөлбөрийн захирал Жеймс Макганы ахалсан судалгааны багийн 2018 оны тайланд⁶ бичсэнээр хамгийн олон бодлогын судалгааны хүрээлэн буюу 1872 хүрээлэн АНУ-д ажиллаж байгаа бол БНХАУ-д 512, Их Британид 444, Энэтхэгт 293, Германд 225 хүрээлэн тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн уг тайлангаас харахад батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийдэг бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн жагсаалтын эхний 10-д АНУ-аас 6. Их Британиас 2, Франц болон Японоос тус бүр 1 хүрээлэн багтсан бол олон улсын харилцаа, гадаад бодлогын чиглэлээр судалгаа хийдэг хүрээлэнгүүдийн жагсаалтын эхний 10-д АНУ-ын 5, Их Британийн 2, Франц, Япон, БНХАУ-ын тус бүр 1 хүрээлэн багтсан байна.

Үүний зэрэгцээ гадаад орнуудын шинжлэх ухааны салбарт ажиллан судалгаа шинжилгээний ажил эрхлэх судлаачдын тоо ч харьцангуй нэмэгдэж байна. Тухайлбал 2014 оны байдлаар 1 сая хүнд ноогдох судлаачдын тоогоор Финлянд улс 7110 судлаачтайгаар тэргүүлж байгаа бол Япон 5500, АНУ 4600 судлаачтайгаар

Энхбайгаль.Б. "Бодлогын судалгааны институцийн хөгжлийн тайлан 2015". Үндэсний Хөгжлийн Хүрээлэн. УБ.. 2015. 8 дахь тал.

²Diane Stone. "Think Tanks and Policy Analysis", Handbook of Policy Analysis: Theory, Methods and Politics. New York, Markel Dekker Inc. 2006 pp. 149-157

³ The Royal United Services Institute for Defense and Security Studies

⁴ Niall McCarthy. "The Countries with the Most Think Tank Worldwide". Forbes, August 13. 2018

⁵"Global Go to Think Tank Index Report"

⁶ McGann, James G. "2018 Global Go to Think Tank Index Report". TTCSP Global Go To Think Tank Index Reports. University of Pennsylvania. 2019. pp. 130-132

https://repository.upenn.edu/think_tanks/16

удаалж байна.¹ Харин ЮНЕСКО-гийн Статистикийн Хүрээлэн 2016 онд 1 сая хүнд ногдох судлаачдын 1996 оны үеийн тоог 2016 онтой харьцуулан судалсан бөгөөд 1 сая хүнд оногдох эрдэм шинжилгээний ажилтны дэлхийн дундаж 1996 онд 1070 байсан бол 2015 оны байдлаар 1473 болж өсчээ.*^{2 3} Мөн уг судалгаанаас харахад нэлээд хэдэн улсын судлаачдын тоо 20 жилийн дотор 100-аас 300 шахам хувь өссөн байна. Тухайлбал БНХАУ-ын судлаачдын тоо 438-аас 1206 болж, Дани улсынх 3178-аас 7515 болж, Германых 2827-оос 4893 болж, Унгарынх 1007-оос 2646 болж, Өмнөд Солонгосынх 2173-аас 7113 болж, Их Британийх 2489-өөс 4430 болж тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Гэтэл зарим нэг цөөн улсын судлаачдын тоо буурсан байгаагаас ОХУ-ын судлаачдын тоо 3796-аас 2979 болж, Румыных 1329-өөс 912 болж тус тус буурчээ? Мөн өндөр хөгжилтэй орнуудын шинжлэх ухааны салбарт зарцуулж буй хөрөнгө нь 2013 оны байдлаар тухайн улсын ДНБ-ний 2,04 хувьтай тэнцэж байсан нь маш өндөр үзүүлэлт юм.⁴ Энэхүү 2,04 хувийн 1 орчим хувь нь засгийн газрын хөрөнгө байдаг бол үлдэх хувь нь гол төлөв бизнесийн салбарынхны хөрөнгө оруулалт байдаг ажээ.

Дээрхээс харахад өндөр хөгжилтэй улсууд улс төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцож буй бодлогын судалгааны хүрээлэнгийн тоо, гүйцэтгэх үүргийг жил ирэх тусам нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч буйгаас АНУ бүхий л үзүүлэлтээр тэргүүлж байна. Энэ улсын бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн чанар чансаа, тоо хэмжээ ч бусад улсаас эрс ялгарч байна. Судалгааны өгүүллийн үндсэн зорилго нь АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад үзүүлж буй бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн гүйцэтгэж буй үүргийг судлаж Монгол улсын хувьд хэрэгжүүлж болохуйц санал зөвлөм гаргахад оршиж байна.

АНУ-ын Бодлогын Судалгааны Хүрээлэнгүүд, тэдгээрийн гадаад бодлогын шийдвэр гаргалтад гүйцэтгэж буй үүрэг

АНУ-д 4 жил тутам болдог ээлжит сонгуулийн үр дүнд ерөнхийлөгч, Сенат болон Төлөөлөгчдийн танхимын гишүүд өөрчлөгдөн, дээд түвшний шийдвэр гаргагчид солигдсоноор АНУ-ын гадаад бодлогод мэдэгдэхүйц өөрчлөлт ордог. АНУ шиг сонгуулийн үр дүнгээс улбаалсан засаг захиргааны шинэчлэлийн улмаас дотоод улс төрийн бодлого төдийгүй гадаад болон үндэсний аюулгүй байдлын бодлогын шийдвэр гаргах дээд түвшний албан тушаалтнуудыг өөрчилдөг өөр ардчилсан тогтолцоотой улс тоотой цөөн билээ. Ялангуяа ерөнхийлөгчийн албан тушаал нэг намаас нөгөө намд шилжихэд гадаад бодлогын шийдвэр гаргалтад гардан оролцдог (ҮАБ-ын Зөвлөлд багтдаг) бүх л ахлах албан тушаалтнууд солигддог. Дэлхийн бусад олон улсаас ялгарах АНУ-ын нэг гол онцлог бол энэхүү засаглалын институтын өөрчлөлт юм. Шинээр сонгогдсон ерөнхийлөгч, түүний засгийн газар нь шийдвэр гаргалтад оролцдог дээд түвшний удирдлагын бүтцийг бараг тэр чигээр нь өөрчилдөг төдийгүй дунд шатны албан тушаалтнуудыг мөн олноор нь солидог.⁵ Ингэснээр улс үндэстний амин чухал ашиг сонирхолыг хөндсөн асуудлаар шийдвэр

¹Сономдагва.Ч. "Монгол улс хэдэн хүрээлэн, төв. хичнээн эрдэмтэн судлаачтай вэ?" Монголын залуу эрдэмтэдийн холбооны вэб сайт. <http://www.mysa.mn/mn/news/item/129-2015-01-22-05-21-16>

² UNESCO. Researchers in R&D (per million people). 2016.

<https://data.worldbank.org/indicator/sp.pop.scie.rd.p6>

³ Men тэнд

⁴ Andrew Steele. How much does the world spend on science? The Conversation., 2013 <http://theconversation.com/infographic-how-much-does-the-world-spend-on-science-14069>

⁵ Rohinton P. Medhora & John de Boer. "The Rise and Influence of the Foreign Policy Think Tank". United Nations University. Center for Policy Research. November 30, 2015

гаргах үйл явц гадаад бодлогын мэдлэг чадвар, туршлага багатай хүмүүсийн гарт шилждэг. Хэдийгээр шинээр сонгогдсон ерөнхийлөгч өөрийн багийг аль болох бага хугацаанд бүрдүүлэн үүрэгт ажилд нь томилдог ч шинээр томилогдсон ахлах албан тушаалтнууд ажилдаа гаршиж, нөхцөл байдлыг ойлготлоо нэлээд хэдэн сар шаардлагатай болдог байна.¹

Дээрх улс төрийн нөхцөл байдлыг үл харгалзан АНУ-ын гадаад болон аюулгүй байдлын бодлого нь өмнөх уламжлалаа хадгалан тасралтгүй хэрэгжиж байдаг. Энэхүү байдлын учир шалтгааныг АНУ-ын шийдвэр гаргах механизмын хэд хэдэн онцлог, давуу байдалтай холбон тайлбарлаж болно. Гэхдээ АНУ-ын шийдвэр гаргах механизмын нэг гол давуу тал нь “Think tank” хэмээн англиар нэрийддэг “Бодлогын Судалгааны Хүрээлэнгүүд” юм. Өмнө өгүүлсэнчлэн 2018 оны байдлаар АНУ-д 1872 бодлогын судалгааны хүрээлэн үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр нь засгийн газрын эрх мэдлийн шилжилтийн хугацаанд АНУ-ын гадаад бодлого, аюулгүй байдлын шийдвэр гаргалтад нэн шаардлагатай бодлогын судалгааг тасралтгүй хийж бодлогын залгамж чанарыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байдаг.²

Энэхүү “Think tank” хэмээх нэр томъёо нь АНУ-д 1950-иад оны сүүл үеэс хэрэглэгдэж эхэлсэн ч гадаад бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийдэг судалгааны байгууллагыг бий болгох санаа 20-р зууны эхэн үеэс эхлэлтэй юм. Тухайлбал, энх тайвныг түгээн дэлгэрүүлэхийн тулд “Олон Улсын Энх Тайвны төлөөх Карнегийн Төв”-ийг 1910 онд байгуулсан бол 1916 онд “Брукингийн Хүрээлэн”, 1919 онд “Хуверийн Хүрээлэн”, 1921 онд Нью Йоркт, 1922 онд Чикагод “Гадаад Харилцааны Зөвлөл”-ийн салбарыг хууль эрх зүй, бизнес, банк санхүүгийн байгууллагын санхүүжилттайгаар тус тус байгуулсан байна. Эдгээр оролдлогууд нь 19-р зууны үеэс эхлэлтэй АНУ-ын гадаад бодлогод давамгайлж байсан “тусгаарлах үзэл”³ төгсгөл болж байхад хийгдэж эхэлсэн ба Америкийн улс төрийн элитүүдийг бодлогын хувьд нэгтгэх, соён гэгээрүүлэх, идэвхжүүлэхэд чиглэгдэж байсан юм.

Гэхдээ АНУ-ын бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн оргил цэцэглэлтийн үе нь дэлхийн хоёрдугаар дайны дараа тохиосон ба АНУ-ын хилийн чанад дахь нэр хүндийг өсгөх, идэвхтэй гадаад харилцаа холбоо тогтоох. ЗХУ болон коммунизмын өсөлтийг тогтоон барихын сацуу ардчилсан үзлийг түгээн дэлгэрүүлэх, мөн НҮБ, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээр гэх мэт шинээр байгуулагдсан олон улсын институтуудын үр өгөөжийг нэмэгдүүлэх, үүний тулд дээд түвшний шийдвэр гаргах удирдлагыг бэлтгэх хэрэгцээ илтэд нэмэгдэх болсон. Энэ улс түүхэндээ анх удаа иж бүрэн цогц байдлаар хөгжсөн, өргөн цар хүрээг хамарсан, гадаад бодлогын асар том стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай тулгарсан.

Үүний тулд олон улсын харилцаа, гадаад бодлого, геополитик, аюулгүй байдлын судалгаагаар мэргэшсэн судлаач эрдэмтэдийн туслалцаа хэрэг болсон байна.

2-р дайны дараа байгуулагдсан анхны ийм чиглэлийн судалгааны байгууллага нь өнөөгийн “РАНД Корпораци”⁴ юм. Энэхүү бодлогын судалгааны хүрээлэн нь

Robert E.Hunter. "Think tanks: Helping to Shape U.S Foreign and Security Policy". US Foreign Policy Agenda, AN ELECTRONIC JOURNAL OF THE U.S. DEPARTMENT OF STATE. Volume 5. Number 1, March 2000.

² Rohinton P. Medhora & John de Boer. "The Rise and Influence of the Foreign Policy Think Tank". United Nations University, Center for Policy Research. November 30, 2015

³ Изоляционизм.

⁴ “RAND Corporation” буюу Судалгаа, Хөгжлийн Корпораци нь АНУ-ын Засгийн газрын захиалгаар стратегийн судалгаа хийдэг томоохон Бодлогын Судалгааны Төв юм.

1947 онд батлагдсан “Үндэсний Аюулгүй Байдлын тухай хууль”-ийн хүрээнд АНУ-ын армиас салж бие даах болсон АНУ-ын Нисэх Хүчний' удирдлагын хүсэл шаардлагын дагуу зэвсэгт хүчний энэхүү шинэ салбарын бодлого, төлөвлөгөөг боловсруулах зорилгоор байгуулагдсан.

Мөн цагаан ордны нөлөө байхгүй болохыг батлахын тулд Вашингтоноос аль болох хол буюу Калифорни мужийн Санта-Моникад байгуулахаар төлөвлөжээ. РАНД корпораци нь гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын чиглэлээр өндөр түвшний, бодитой судалгаа дүн шинжилгээ хийдэг бодлогын судалгааны хүрээлэнгийн анхны шалгуур нь болж чадсан.

Дараагийн хэдэн жилийн хугацаанд РАНД Корпораци нь засгийн газрын зэрэгцээ янз бүрийн чиглэлээр судалгааны захиалга өгч санхүүжилт хийдэг засгийн газрын бус байгууллагуудтай хамтран ажиллах болсон. Үүнтэй холбоотойгоор Пентагон батлан хамгаалахын чиглэлээр судалгаа хийдэг “Батлан Хамгаалахын Судалгааны Хүрээлэн”, “Тэнгисийн Цэргийн Судалгааны Төв” гэх мэт хэд хэдэн байгууллагыг шинээр байгуулсан юм. Эдгээр байгууллагуудын зэрэгцээ байгалийн шинжлэх ухааны чиглэлээр судалгаа хийдэг Калифорнийн Их Сургуулийн Лос-Аламосын Үндэсний Лаборатори¹ ² болон Лауренс Ливермөүрийн Үндэсний Лаборатори³ зэрэг судалгааны хүрээлэнгүүд үйл ажиллагаа явуулж байв.

Умард Атлантын Гэрээний Байгууллагын дэргэд суух АНУ-ын Байнгын төлөөлөгч асан, Вашингтоны “РАНД корпораци” судалгааны хүрээлэнгийн ахлах зөвлөх Роберт Хантер хэлэхдээ “сүүлийн хагас зуун жилийн хугацаанд АНУ-ын дэлхийн бодлогод эзлэх байр суурь өсөхийн хэрээр АНУ-ын гадаад болон үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулалтад гүйцэтгэж буй бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн үүрэг болон ТОО хэмжээ эрс өссөн”.

Эдгээр хүрээлэнгүүд нь АНУ-ын ерөнхийлөгч, конгресс болон бусад шийдвэр гаргагчдад нөлөөлөх, АНУ-ын ирээдүйн бодлогыг боловсруулах, улс төрийн бодлого боловсруулалт ба шийдвэр гаргалтад оролцдог тал бүрийн оролцогчдыг шийдвэр гаргах үйл явцад татан оролцуулах, мөн иргэд олон нийтийн боловсролыг нэмэгдүүлэх зэрэгт чухал үүрэг гүйцэтгэсэн⁴ хэмээжээ.

Америк даяар томоохон корпорациуд, үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас санхүүждэг судалгааны хүрээлэнгүүдийн зэрэгцээ баруун эргийн Лос Анжелесийн Калифорнийн Их Сургууль, Стэнфордын Их Суруулиас зүүн эргийн Харвард. Массачусетсийн Технологийн Дээд Сургууль зэрэг их дээд сургуультай хамтарсан болон бие даасан хэлбэрийн олон тооны судалгааны байгууллага үүсгэн байгуулагдсан ба эдгээр нь АНУ-ын гадаад бодлогыг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Эдгээрийн зэрэгцээ олон нийтийн хөрөнгөөр боссон “АНУ-ын Энх Тайвны Хүрээлэн”, “Ардчилалын төлөөх Үндэсний Төв” зэрэг ардчилалыг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий тусгай байгууллагууд үйл ажиллагаагаа идэвхтэй явуулах болсон байна. “Ардчилалын Төлөөх Үндэсний Төв” нь жишээлбэл 4 салбараас бүрддэг ба нэг нь Бүгд Найрамдах Нам, нөгөө нь Ардчилсан Нам, гурав дахь нь Үйлдвэрчний эвлэл, үлдсэн нь бизнесийн салбартай хамтран ажилладаг. Америкийн бодлогын судалгааны хүрээлэнгүүд нь “гадаад”,

¹ <https://www.airforce.com/mission/history>

² 1942 онд байгуулагдсан ба анхны атомын бөмбөгийг зохион бүтээсэн лаборатори.

³ 10 жилийн дараа байгуулагдсан. анхны ус төрөгчийн зэвсэгийг бүтээсэн лаборатори.

⁴ Robert E.Hunter. "Think tanks: Helping to Shape U.S Foreign and Security Policy", US Foreign Policy Agenda. AN ELECTRONIC JOURNAL OF THE U.S. DEPARTMENT OF STATE. Volume 5. Number 1. March 2000.

“олон улсын”, “стратегийн”, “глобал”, “судалгаа шинжилгээ”, “бодлого”, “төв”, “хүрээлэн”, “зөвлөл” гэх мэт холбоо үгсээр нэрлэгдэх болсон.

Эдгээр судалгааны байгууллагууд нь бүс нутгийн асуудлаас эхлээд эдийн засаг, цэрэг дайны асуудал гэх мэт олон тооны чиглэлээр судалгаа хийдэг ба ялангуяа АНУ-ын гадаад бодлоготой холбоотой асуудлаар нэгдсэн нэг ойлголтод хүрэх зорилгоор судалгаа хийх, улс төрийн шийдвэр гаргагчдад эдгээр асуудлаар улс төрийн дэмжлэг үзүүлэхийн тулд тодорхой төлөвлөгөөний хүрээнд ажилладаг.

АНУ-ын топ 20 Бодлогын Судалгааны Хүрээлэн оа тэдгээрийн жилийн орлого (2015-2016 оны байдлаар. ан долларгаар)

1. Brookings Institution	(орлого 117,336 сая)
2. Council on Foreign Relations (CFR)	(орлого 101,553 сая)
3. Center for Strategic and International Studies (CSIS)	(орлого 43,431 сая)
4. Carnegie Endowment for International Peace	(орлого 46,973 сая)
5. Woodrow Wilson International Center for Scholars	(орлого 14,425 сая)
6. RAND Corporation	(орлого 351.7 сая)
7. Heritage Foundation	(орлого 91,903 сая)
8. Cato Institute	(орлого 37.3 сая)
9. Center for American Progress (CAP)	(орлого 45,156 сая)
10. Peterson Institute for International Economics (PIIE)	(орлого 8,980 сая)
11. American Enterprise Institute for Public Policy Research (AEI)	(орлого 75,066 сая)
12. Urban Institute	(орлого 93,880 сая)
13. National Bureau of Economic Research (NBER)	(орлого 33,630 сая)
14. Atlantic Council	(орлого 23,507 сая)
15. Center for a New American Security (CNAS)	(орлого 8,789 сая)
16. World Resources Institute (WRI)	(орлого 90 сая)
17. James A. Baker III Institute for Public Policy	(орлого 6, 76 сая)
18. Hoover Institution	(орлого 69,477 сая)
19. Pew Research Center	(орлого 44,409 сая)
20. Belfer Center for Science and International Affairs'	(орлого нь тодорхой)

АНУ-ын топ 20-д багтсан бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн жилийн орлого нь багадаа 6 сая 760 мянган америк доллар байхад хамгийн ихдээ 351 сая 700 мянган америк доллар, эдгээр 20-ийн нийт орлого 1 тэрбум 630 сая 427,5 мянган доллар болж байна. Үүнээс гадна нийгэм эдийн засгийн нөлөө бүхий хүмүүс болон томоохон корпорацудын грант, хандив зэрэг тусламж нь АНУ-ын бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн санхүүжилтийн нэг том эх үүсвэр болдог^{1 2} бол засгийн газар мөн тодорхой санхүүжилт хийдэг. Жишээ нь 2005 оны байдлаар АНУ-ын засгийн газраас санхүүжиж байгаа гол 15 хүрээлэнгийн жилийн дундаж санхүүжилт нь 32.8 сая доллар ажээ.³

¹ Пенсильваны Их Сургуулийн судалгаагаар "Их сургуулийн дэргэдэх дэлхийн номер нэг бодлогын судалгааны хүрээлэн"-ээр тодорсон.

²Rohinton P. Medhora & John de Boer. "The Rise and Influence of the Foreign Policy Think Tank". United Nations University. Center for Policy Research. November 30. 2015

³Энхбайгаль.Б. "Ухаалаг төр ба судалгаанд суурилсан бодлого: Судалгаа шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаа. төрийн бодлогын чанарын хамаарал". Ньюс.мн вэб сайт. 2014 оны 09-р сарын 26.

<https://news.mn/r/674560/>

Хүснэгт. 1. АНУ-ын гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлээр судалгаа хийдэг бодлогын судалгааны гол гол хүрээлэнгүүдийн дэлхийн чансаанд эзлэж буй байр суурь (2015 оны байдлаар).

№	АНУ-ын Бодлогын Судалгааны Хүрээлэн (байгуулагдсан он)	Дэлхийн чансаа (гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлийн топ 40 хүрээлэн)
	Стратегийн болон Олон улс судлалын төв. 1962 он Center for Strategic and International Studies (CSIS)	1
	Судалгаа, Хөгжлийн Корпораци. 1948 он. RAND Corporation	3
	Брукингийн Хүрээлэн. 1916 он. Brookings Institution	4
	Шинэ Америкийн Аюулгүй Байдлын Төв. 2007 он. Center for a New American Security (CNAS)	6
	Олон Улсын Энх Тайвны төлөөх Карнегийн Төв. 1910 он. Carnegie Endowment for International Peace	7
	Атлантын Зөвлөл. 1961 он. Atlantic Council [of the US]	9
	Гадаад Харилцааны Зөвлөл. 1921 он. Council on Foreign Relations (CFR)	11
	Катоны Хүрээлэн. 1974 он. Cato Institute	13
	Стратегийн болон Төсвийн Үнэлгээний Төв. 1983 он. Center for Strategic and Budgetary Assessments (CSBA)	14
	Шинжлэх ухаан ба Олон улсын харилцааны Белферийн төв. 1973 он. Belfer Center for Science and International Affairs	17
	Төрийн Бодлогын Судалгааны Америкийн Бизнесийн Хүрээлэн. 1943 он. American Enterprise Institute for Public Policy Research (AEI)	20
	АНУ-ын Энх Тайвны Хүрээлэн. 1984 он. United States Institute of Peace (USIP)	21
	Америкийн Хөгжил Дэвшлийн Төв. 2003 он. Center for American Progress (CAP)	25
	Вудро Вильсоны Олон Улс Судлалын Төв. 1968 он. Woodrow Wilson International Center for Scholars	27
	Хуверийн Хүрээлэн. 1919 он. Hoover Institution [on War, Revolution and Peace]	33
	Өв Уламжлалын Сан. 1973 он. Heritage Foundation	36

АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад ихээхэн нөлөөтэй бодлогын судалгааны хүрээлэнгүүд нь гол төлөв Вашингтонд байрладаг Эдгээр

'McGann, James. "2015 Global Go to Think Tank Index Report". TTCSP Global Go To Think Tank Index Reports. University of Pennsylvania.. 2016. p.75.

байгууллагууд нь бүгд судалгааны чиглэлийнх байсан бол нэлээд нь олон нийтийн оролцоотой үйл ажиллагаа явуулдаг байв. Өнөөгийн байдлаар “Олон Улсын Энх Тайвны төлөөх Карнегийн Төв”, “РАНД Корпораци”, “Гадаад Харилцааны Зөвлөл”¹, “Брукингийн Хүрээлэн”, “Стратегийн болон Олон улс судлалын Төв”, “Төрийн Бодлогын Судалгааны Америкийн Бизнесийн Хүрээлэн”, “Бодлогын Судалгааны Хүрээлэн”, “Өв Уламжлалын Төв” зэрэг АНУ-ын хамгийн нэр хүнд бүхий судалгааны байгууллагууд Вашингтонд байрлан ажиллаж байна.

Судалгааны байгууллага тус бүрдээ өөр өөрсдийн чиглэл сонирхолтой бөгөөд зарим нь улс төрийн хүрээний судалгаа хийдэг байхад нөгөө зарим нь намын захиалгат судалгааны ажил гүйцэтгэж байдаг. Зарим бодлогын судалгааны хүрээлэнгүүд нь судалгааны ажлаа хэвлэн нийтлүүлэхэд илүүтэй анхааран ажиллаж байхад зарим нь Конгрессийн гишүүдэд зөвлөмж гаргах зорилготой ажилладаг. Хэд хэд нь АНУ-ын засаг захиргаанд нөлөөлөн ажиллахыг илүүд үздэг бол үлдсэн зарим нь дээрх бүгдийг хамруулан судалгаа, дүн шинжилгээ хийн ажилладаг.

Америкийн гадаад бодлогын чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийдэг бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн хувьд хоёр үндсэн онцлог шинжтэй.

Нэгдүгээрт: Эдгээр хүрээлэнгүүдийн ихэнх нь гадаад бодлогын янз бүрийн хувилбараас хамгийн зөв хувилбар. зөв үзэл баримтлалыг сонгохын тулд ерөнхийлөгчийн засаг захиргаа, конгрессын гишүүд, бизнесийн болон академик салбарын улс төрч, судлаач шинжээчдийн санаа бодлыг сонсож, өргөн хүрээний хэлэлцүүлэг өрнүүлэн нэгдсэн нэг шийдвэрт хүрэхийн тулд анхаарлаа хандуулан ажилладаг.

Эдгээр үйл ажиллагаа нь зөвхөн мэдээлэл хуваалцах эсвэл хамгийн шилдэг санааг хөгжүүлэхэд төлөвлөгдөөгүй. Харин илүү өргөн хүрээний улс төрийн дэмжлэгийг авахуйц, гадаад бодлогын хамгийн чухал асуудлаар боломжтой түвшинд нэгдмэл нэг байр сууринд хүрэхэд дөхөм үзүүлэх, үзэл бодлын хамгийн том зөрчил нь юунд байгаа, АНУ нь гадаад бодлогын ямар чиг хандлагыг дагаж мөрдөх хэрэгтэй вэ гэдгийг судалж, боловсруулахад чиглэгддэг.

Ийм учир эдгээр хүрээлэнгүүд нь нэг ёсны АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах механизмын “нууц зэвсэг” юм. Энэ нь Конгресс болон ерөнхийлөгчийн засаг захиргааны хүрээний янз бүрийн үзэл бодол, байр суурь бүхий улс төрийн шийдвэр гаргагчдын бодлогын зөрөөг арилгахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг.^{1,2}

АНУ-ын гадаад бодлого, дипломат ажиллагааны түүхээс харахад гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын асуудлаар 2 намын байр суурь зөрчилдвөл улс төрийн хувьд ямар хор уршигтай болохыг үе үеийн ерөнхийлөгчийн засаг захиргаа, бүхий л цаг үеийн конгрессийн гишүүд ойлгож, энэ алдаанаасаа суралцаж байдаг. Хоёр намын системтэй АНУ-ын хувьд гадаад бодлогын нэгдмэл, залгамж чанараа хадгалсан шийдвэр гаргахад эдгээр бодлогын судалгааны хүрээлэнгүүд маш чухал юм.

Хоёрдугаарт: Гадаад бодлогын чиглэлийн судалгааны хүрээлэнгүүд нь ерөнхийлөгч болон Конгрессийн шийдвэр гаргалтад зөвлөмж гаргах чадвартай өндөр эрэмбийн шинжээч, судлаачдын хүн нөөцийн гол эх сурвалж юм.

¹ “РАНД Корпораци”, “Гадаад Харилцааны Зөвлөл” хоёр нь Нью Йоркод төвтэй байсан бол хожим Вашингтонд салбараа байгуулсан байна.

² Robert E.Hunter, “Think tanks: Helping to Shape U.S Foreign and Security Policy”, US Foreign Policy Agenda. AN ELECTRONIC JOURNAL OF THE U.S. DEPARTMENT OF STATE, Volume 5, Number 1, March 2000.

Үүний зэрэгцээ ерөнхийлөгчийн ажлын алба болон Конгресст алба хашиж байсан улс төрчид, улс төрийн албан хаагчдын зарим нь гадаад бодлогын чиглэлээр дагнан ажиллахыг хүсвэл өөрийн улс төрийн туршлага дээрээ тулгуурлан эдгээр судалгааны байгууллагуудад шилжин ажиллах явдал нэлээд тохиолддог.

АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтын механизмын бас нэг гайхалтай онцлог шинж нь энэхүү шилжилт хөдөлгөөн бөгөөд бодлогын судалгааны хүрээлэнгүүдэд ажиллаж байсан судлаачдыг улс төрийн шийдвэр гаргалтын түвшний албан тушаалд томилон ажиллуулдаг бол улс төрийн албан тушаалтнуудыг судалгааны ажилд ихээр татан оролцуулдаг ба энэ нь өөр бусад улсад ховор тохиолддог үзэгдэл юм.

Үнэн хэрэгтээ, АНУ-д маш цөөн тооны улс төрийн албан тушаалтан л бодлогын судалгааны хүрээлэнгүүдэд судалгаа шинжилгээний ажил хийлгүйгээр гадаад бодлогын шийдвэр гаргах өндөр түвшний албан тушаалд томилогдон ажилласан байдаг.

АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөх, Төрийн нарийн бичгийн даргын албан тушаал хашиж байсан олон улс төрчид гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлийн судалгааны байгууллагад өндөр эрэмбийн судалгааны ажил хийж байсан хүмүүс байдаг. Жишээ нь АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөхөөр ажиллаж байсан Х.Киссинжер, З.Безинский, Колин Пауэл, Брент Скоукрофт¹, Кондолиза Райт, Херберт Макмастер болон ерөнхийлөгч Д.Трампын зөвлөх Жон Болтон зэрэг АНУ-ын бүх цаг үеийн УАБ-ын зөвлөхүүд бүгдээрээ гадаад бодлого, аюулгүй байдлын чиглэлийн бодлогын судалгааны хүрээлэнгүүдэд ахлах судлаачаас захирал хүртэлх албыг хашиж байсан бол Х.Кисенжер², М.Олбрайт³, Кондолиза Райт⁴, Майк Помпео⁵ зэрэг судалгааны байгууллагад ажиллаж байсан судлаачид хожим нь төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдон ажиллаж байв.

Дүгнэлт

Эдгээрийг эцэст нь нэгтгэн дүгнэвэл, 20-р зууны сүүл хагас болон 21-р зууны эхэн үеэс АНУ-ын гадаад болон үндэсний аюулгүй байдлын бодлогын шийдвэр гаргалтад бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн гүйцэтгэх үүрэг ихээр нэмэгдсэн ба АНУ-ын олон улсын харилцаан дахь байр суурь, нэр хүндийг өсгөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Ийм учир бодлогын судалгааны хүрээлэнгүүдээр судалгаа хийлгэх сонирхолтой төрийн болон төрийн бус байгууллагын тоо ч эрс өсөх хандлагатай болсон. Үүнийг дагаад эдгээр хүрээлэнгийн төсөв санхүүгийн боломж нэмэгдсэн бөгөөд төрөөс ч санхүүжилт хийх тал дээр анхааран ажиллах болжээ. Иймд шинжлэх ухааны мэдлэг чадвар өндөр, судалгаа шинжилгээний ажил эрхлэх туршлагатай судлаач шинжээчид энэ салбарт ажиллах явдал түгээмэл болсон байна.

АНУ-ын туршлагаас харахад бодлогын судалгааны тодорхой хувь нь төрийн санхүүжилтээр хийгддэг, судалгааны ажлаас олж буй орлогод татварын хөнгөлөлт

¹Office of the Historian Bureau of Public Affairs United States Department of State."History of the National Security Council, 1947-1997", *National Security Council White House*. August 1997. <https://fas.org/irp/offdocs/NSChistory.htm>

² Тадаад Харилцааны Зөвлөл" болон "РАНД Корпораци"-д ажиллаж байв.

³Вудро Вильсоны Олон Улс Судлалын Төв" болон "Үндэсний Бодлогын Төв"-д ажиллаж байсан.

⁴ Стэнфордын Их Сургуульд профессор, "Олон Улс Судлалын Хүрээлэн" болон "Хуверийн Хүрээлэн"-д тус тус ахлах судлаачаар ажиллаж байв.

⁵Харвардын Хуулийн Сургуулийн докторын зэрэг хүртсэн ба "Эрх зүй ба Төрийн Удирдлагын Харвардын Сэтгүүл" ба "Харвардын Хууль. Эрх зүйн Тойм" сэтгүүлүүдэд ерөнхий редактороор ажиллаж байв.

үзүүлдэгээс биш 100 хувь төрийн мэдлийн судалгааны байгууллага гэж байхгүй. АНУ-ын улс төр, бизнесийн салбарынхан шийдвэр гаргалтад шаардлагатай бодлогын судалгааны захиалгыг өндөр үнэлгээтэйгээр төрийн бус, хувийн хэвшлийн судалгааны байгууллагуудад өгч гүйцэтгүүлдэг тул эдгээр хүрээлэнгүүд ихээхэн ашиг орлоготой ажилладаг. Иймд судлаачид нь зөвхөн эрдэм шинжилгээний ажилдаа л төвлөрөн, чанартай бодлогын зөвлөмжийг боловсруулж чаддаг. Их сургуулиуд нь судалгааны ажлын захиалга ихээр авдаг тул бодлогын судалгаа хийхэд ихээхэн хөрөнгө санхүү, хүн хүч гаргадаг ба профессорууд нь багшлахын хажуугаар бодлогын судалгаанд цаг заваа ихээр зарцуулдаг. АНУ-ын хувьд гадаадын санхүүжилттэй бодлогын судалгаа хийдэг байгууллага тооны хувьд цөөн байхаас гадна гадаад бодлого, аюулгүй байдлын гэхээс илүүтэй бизнесийн чиглэлийн зөвлөмж боловсруулан ажилладаг байна.

АНУ-ын улс төрийн намууд бодлогын судалгааны хүрээлэнгүүдэд ихээхэн ач холбогдол өгч ажилладаг. Иймээс улс төрийн намын санхүүжилттэй бодлогын судалгааны хүрээлэнгүүд энэ улсын шийдвэр гаргалтад маш том нөлөө үзүүлдэг. АНУ-ын гол хоёр намаар дамжин шийдвэр гаргалтын түвшинд хүрч ажиллаж буй улс төрчид, конгрессийн гишүүд бодлогын судалгааны хүрээлэнгүүдийн зөвлөмжийг дагаж мөрдөхөөс гадна өөрсдөө ч тэдгээр судалгааны байгууллагад улс төрийн карьерийнхаа эхэн болон төгсгөлд ажилладаг байна.

АНУ-ын гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай бодлого боловсруулах, шийдвэр гаргалтын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалахад шаардлагатай бодлогын зөвлөмжийг боловсруулахын зэрэгцээ олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр маш чухал ажлыг эдгээр судалгааны байгууллагууд хийж иржээ. АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах түвшинд ажиллах мэргэжлийн ур чадвартай, шинжлэх ухааны өндөр мэдлэгтэй хүмүүсийг бэлдэх тал дээр АНУ-ын бодлогын судалгааны хүрээлэн нэг талаас анхааран ажилладаг бол нөгөө талаас төрийн институтууд судалгааны ажлын туршлагатай хүмүүсээс шийдвэр гаргагчийн түвшинд томилон ажиллуулах дээр мөн онцгой анхаардаг болох нь судалгаанаас тодорхой болж байна. Иймээс бодлогын судалгааны хүрээлэнгүүд нь АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах механизмын салшгүй нэг хэсэг болсон ба эдгээр судалгааны байгууллагуудгүйгээр энэ улсын гадаад бодлогын шийдвэр гаргалтыг төсөөлөхийн аргагүй болжээ.

Дүгнэлтийнхээ төгсгөлд Монгол улсын хувьд АНУ-ын туршлагаас авч хэрэгжүүлж болох дараах хэд хэдэн санал зөвлөмжийг танилцуулж байна. Үүнд:

-Төрийн мэдлийн гадаад бодлогын судалгааны хүрээлэнгийн төсөв, судлаачдын цалинг нэмэгдүүлэн, нийгмийн асуудлыг нь шийдэх тал дээр төрийн зүгээс дорвитой арга хэмжээ авах.

-Хувийн хэвшлийн чадварлаг цөөн хүнтэй судалгааны байгууллагад болон их, дээд сургуулиудын дэргэдэх судалгааны төвүүдэд судалгааны ажлын захиалга өгч хийж гүйцэтгүүлэх тал дээр анхааран ажиллах. Учир нь чанартай судалгаа хийдэг бодлогын судалгааны хүрээлэн олон байх тусмаа сайн бөгөөд судалгааны үр дүн олон байхын хэрээр зөв шийдвэр гаргах сонголт нэмэгдэнэ.

-Их, дээд сургуулиуд ба бусад судалгааны болон бизнесийн байгууллага, салбарын яамны хоорондын уялдаа холбоог сайжруулах, ингэснээр их сургуулиудын дэргэдэх бодлогын судалгааны төвүүдийн санхүүгийн эх үүсвэр нээгдэх бөгөөд үйл ажиллагаа тогтворжино.

- Улс төрийн намууд дэргэдээ бодлогын судалгааны хүрээлэнтэй байхыг хуульчилж тэдгээр хүрээлэнгүүдэд улс төрчдийн олон улсын харилцаа, геополитик, гадаад бодлого, аюулгүй байдлын талаарх мэдлэгийг байнга нэмэгдүүлэх.

- Гадны санхүүжилттэй бодлогын судалгааны хүрээлэнгээс гарч буй тайлан дүгнэлт болон бодлогын зөвлөмжид тодорхой шалгууртай хандах.

- Бодлогын судалгааг хийсэн хүн л түүнийг хэрэгжүүлэх тал дээр анхааран ажиллана. Иймд бодлогын судалгааны хүрээлэнд ажиллаж байсан туршлагатай судлаачдаас төрийн байгууллагын шийдвэр гаргах түвшинд шилжин ажиллах бололцоог хууль эрх зйн хүрээнд бий болгох.

- Зөв боловсруулагдсан гадаад бодлогын шийдвэр хэрэгждэг байхын үндсэн нөхцөл нь улс төрчид “зөн билгээр” биш “судалгаанд суурилсан ” шийдвэр гаргах үйл явц руу шилжих явдал учраас улс үндэстний эрх ашгийг хөндсөн, нэн чухал асуудлаар улс төрчид шийдвэр гаргахын өмнө заавал бодлогын судалгааны хүрээлэнгүүдээр шүүн хэлэлцүүлсэн байх зэрэг болно.

ХУУЛЬ САХИУЛАХҮЙН УДИРДЛАГА

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

*П.Батбаатар- Дотоод хэргийн их сургуулийн
Удирдлагын академийн захирал,
цагдаагийн хурандаа*

Аливаа улс, орны үндэсний аюулгүй байдал, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх механизм, хүний эрх, эрх чөлөөг тууштай хангах, ард иргэдийн амгалан тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн бодлого нэг талаас түүнийг хэрэгжүүлэгч байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын оновчтой байдал, үйл ажиллагааны бодит үр дүнгээр илрэн гарах учиртай.

Гэмт хэргийн бодит үнэн байдлыг шалгаж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлоход томоохон хэмжээний саад учруулж байгаа хэлбэрийн нэг нь гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх, заналхийлэх, тэдэнд шан харамж амлах замаар хуулийн хариуцлагаас мултрах гэсэн оролдлого түгээмэл хэлбэрээр бий болж, хэргийн бодит үнэнийг гуйвуулах, яллагдагч этгээдэд ашигтайгаар шийдвэрлэх, тэдний гэм бурууг хаацайлах сөрөг үр дагавар бий болж байгаа нь хуулийн байгууллагад итгэх ард иргэдийн итгэлийг улам бүр сулруулахад хүргэж байгаа нь нууц биш.

2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хурлаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлагдан гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учрах аюулт эрсдэлийг хамгаалсан эрх зүйн орчинг анх удаа бүрдүүлж өгсөн дэвшилтэт алхам болсон. Гэсэн хэдий ч гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны эрх зүйн орчин, түүний удирдлага, зохион байгуулалтад олон улсын туршлагыг нэвтрүүлэх, төрийн болон бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны